

**БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

[illegible]

хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.2.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Нийгмийн даатгалын сангийн <u>зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.</u> б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулж тэтгэврийг сар бүрийн 1-ний өдөр арилжааны банкаар дамжуулан олгож байна. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд нийт 28037,8 сая төгрөг зарцуулсан. Үүнд: Тэтгэвэрт эхний 5 сарын байдлаар 25313,9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 25289,0 сая төгрөгийг зарцуулж 24,8 сая төгрөгийн хэмнэлттэй. Тэтгэмж 1194,3 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1138,6 сая төгрөг зарцуулж 55,7 сая төгрөгийн хэмнэлттэй. ҮОМШӨ зардлын санд 1716,1 сая төг төлөвлөгөөтэйгээс 1007,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 708,9 сая төгрөгийн хэмнэлттэй. Ажилгүйдлийн тэтгэмж 597,8 сая төгрөгийн төлөвлөгөөтэй, 602,9 сая төгрөгийн зарцуулалттай, 5,1 сая төгрөгийн хэтрэлттэй байна. 2025.05.31-ний байдлаар нийт зардлын батлагдсан төсөв 28822,1 сая төгрөг бөгөөд гүйцэтгэл 28037,8 сая төгрөг, нийт зардлаас 784,3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.	95
2.4.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан,	Нийгмийн даатгалын сангийн <u>санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан,</u>	Sicos санхүүгийн шинэ программаар 2024 оны жилийн эцсийн нийгмийн даатгалын сангийн тайланг гаргасан.	

	хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	2025 оны 1-р улирлын нийгмийн даатгалын сангийн тайланг шинэ системээр гаргахаар тулгалт хийж байна. Тэтгэмжийн тайлангууд гарсан, тэтгэврийн тайлангийн хувьд жагсаалтаар олгосон тэтгэврийн олголт үүсгэн сангийн хаалтууд хийгдээд байна. 2025 оны 2 дугаар улирлын тайлангийн бэлтгэл ажлууд хийгдэж байна.	96.7
2.8.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, <u>даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.</u>	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. Системийн алдаанаас шалтгаалсан алдаатай хүсэлтийн залруулгыг тухай бүр хийж, нотлох баримтуудыг архивлан оруулж байна.	95
2.10.	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) <u>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр</u>	2024 оны жилийн эцсийн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр шинэчлэн баталгаажуулсан байна. Тэтгэмжийн сангийн тайлангаар 317584,61 мянган төгрөгийн өглөг, тэтгэврийн сангийн тайлангаар 17,610.61 мянган төгрөгийн авлага, 52,872.73 мянган төгрөгийн	85.

					бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	өглөгтэй гарсныг эзэн холбогдогч бүрээр баталгаажуулсан.	
Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;	-	- Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ.	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 99,81 хувийн гүйцэтгэлтэй байна.	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 5238 тэтгэвэр авагчил 25,286,540.2 мянган төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 136 тэтгэвэр авагчид 925,671.2 мянган төгрөгийн тэтгэвэр, этгэмжийн даатгалын сангаас давхардсан тоогоор 1611 хүсэлтээр 1,138,448.76 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 602,913.31 мянган төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 81,309.37 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон тухай мэдээллийг цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулахад нь мэдээллээр хангаж ажиллав. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 73%, бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал 41%, нийт үнэлгээ 74 хувьтай байна.	100
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.	Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх;		- 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний	2024 онд нийт 637 албан бичиг ирсэн. Тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал 99.8 хувьтай байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна.	Тайлант оны өмнөх жил Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлсэнтэй холбогдон, тайлант онд дээд газраас ирүүлсэн 26 эрхзүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	95

			хэрэгжилтийн үр дүн			2025 оны эхний хагас жилийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт 86.3 %-тай байна. Тэтгэвэр, тэтгэмжийн холбогдолтой 8 зүйл заалтын биелэлтийг гаргаж захиргаа хяналтын хэлтэст нэгтгүүлсэн. ЭММТЗ-өөс хугацаатай тайлан 5, судалгаа 3, журамд санал өгөх 2 албан бичиг ирж хугацаанд нь хүргүүлж ажилласан.	
4.6.	Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;		Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна.	Тус газрын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн.	Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Өмнөх жил буюу 2024 оны ХАСХОМ-ийг 3 албан хаагч 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж, тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв.	100
4.8.	Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах;		-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 83.6%-тай байв.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Тайлант оны өмнөх жил Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлсэнтэй холбогдон, тайлант онд дээд газраас ирүүлсэн 26 эрхзүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт 86.3 %-тай байна.	95
Зорилт 4.1: “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.1.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх		-Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах, -Нийт албан	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа	АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэлийг нийт албан хаагчдад түгээлээ. АТГ, НДЕГ, БНДГ-ын пейж	100

	сургалтыг зохион байгуулах;		хаагчдыг 100% хамруулсан байна.	урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	мөрдөж ажиллана.	хуудсаар түгээсэн "Авлигын эсрэг нэгдье" уриалгын 6 удаагийн мэдээ мэдээллийг нийт албан хаагчид өөрийн пейж хуудсаараа бусдад хуваалцаж соён гэгээрүүлэх ажилд оролцож байна.	
4.1.2.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		- Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх 50 удаагийн сургалтад давхардсан тоогоор 284 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна.	Газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөө, ХНХЯ, НДЕГ -аас ирүүлсэн чиглэлийн дагуу тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл, НДЕГ, Багануур дүүргийн ЗДТГ, бусад байгууллагаас цахим болон танхимаар зохион байгуулсан 39 удаагийн сургалтад албан хаагчид оролцож, мэргэжлийн болон холбогдох бусад сэдвүүдээр мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. Зарим сургалтуудаас дурдвал: Sicos системийн талаар нэгдсэн ойлголт өгөх, дадлага хийх, системийн дата мэдээлэл ашиглах сургалтад Захиргаа хяналтын хэлтэс, СБХОХ-ийн дарга нар, Ёс зүйн хорооноос цахимаар зохион байгуулсан сургалтанд ЁЗДХорооны гишүүд, НДЕГ-ын ЁЗДХорооноос цахимаар зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаарх сургалтад 16 албан хаагч, НТБТөвийн сургалтад нийт	100

						албан хаагчид, Хүний нөөцийн мэргэжилтэн А.Ундармаагийн стресс менежмент сэдэвт сургалтад нийт албан хаагчид, нүдний өвчний орчин үеийн оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, тогтооход анхаарах асуудлууд сургалтад магадлагч эмч Б.Балжинням, ХАБЭА-н хууль, тогтоомжийн сургалтад 1 албан хаагч оролцов. Дүүргээс зохион байгуулсан "Гэр бүл-үнэ цэнэ-хариуцлага" сургалтад 1 албан хаагчийг оролцуулав. Эрүүл мэндийн удирдахуйн ухаанаар магадлагч эмч суралцаж магистрийн зэрэг хамгаалсан.	
Зорилт 4.2: "Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.2.1.	Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах;		Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.	Үйлчилгээг хүртээмжтэй явуулах үүднээс иргэдэд аль болох чирэгдэлгүй ойлгомжтой байдлаар өрөө тасалгааны зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандартыг хангуулах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэргэнцэрийн замд	70.8

						халтирахгүй наалтыг шинэчлэн наахаар төлөвлөж байна. Үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд Багануур дүүргийн Насан туршийн боловсролын төвөөс "Харилцаа, хандлага" сэдэвт сургалтад албан хаагчид оролцов. ЭММЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага, цаг ашиглалт, авилга, ашиг сонирхлоос ангид байх зорилгоор 100 онооны 5 заалтбг газрын даргаар батлуулж, гишүүдэд танилцуулан, баталгаажуулсан, мөн иргэний эрхийг дээдлэх зорилгоор "Баталгааны хуудас"-г гаргаж гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан.	
4.2.2.	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;		Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна	Ирсэн дуудлага 4942, дуудлага алдалт дунджаар 29 %.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна.	Тус газар нь 2025 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 3,333 дуудлага хүлээн авсан бөгөөд үүнээс 200 дуудлага алдагдсан байна. Нийт дуудлагын 1173 нь тэтгэмж, үүнээс 86 дуудлага алдсан, 596 тэтгэвэр, үүнээс 43 дуудлагыг техникийн алдаа болон цагийн зөрүүтэй байдал үүссэн бусад шалтгаантай аваагүй байна. Нийт дуудлагын 6%-ийг хүлээн авч чадаагүй бөгөөд дуудлага алдалтын түвшин 10%	95

						хүрээгүй, төлөвлөсөн хэмжээнд ажилласан болно.	
Зорилт 4.3: "Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.3.1.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх		Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, удирдамж, тайлан	2024 онд 1 удаа зохион байгуулсан байна. 2024 онд 1-4 удаа зохион байгуулсан.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Эрүүл мэндийн магадлах төв зөвлөлийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны 09/75 дугаар албан бичгээр Ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулах удирдамж ирсэн бөгөөд Багануур, Налайх, Дорноговь, Булган аймаг хамтран 2025 он 06 дугаар сарын 06-16-ны өдрийн хооронд зохион байгуулна. Үйл ажиллагааны бэлтгэл байдлыг ханган ажиллаж байна, 2025 оны 06 дугаар сарын 12-нд ЭММТЗ-с ИМүзлэгт оруулах иргэдийн нэрс ирнэ. Нэрс ирснээр иргэний амбулаторийн картыг татаж цахимжуулан үзлэгийг зохион байгуулна. ЭММЗ-н хурлын үеэр иргэний иргэний үнэмлэхний лавлагаа, ажилласан жилийн лавлагаа зэргийг үндэслэн цахим мэдээллийн сангийн хяналтыг хийдэг. Иргэний бичиг баримтанд үндэслэн хуралдаж буй тул шинжилгээний бичгүүдэд иргэний овог, нэр, нас зэрэг хувийн мэдээллийг хянаж тулгадаг. Сар бүрийн нас барсан иргэдийн жагсаалтын Эрүүл мэндийн төвөөс авч мэдээллийн сангийн хөдөлгөөнийг хийдэг. 2025 оны	90
			Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан		Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган шалгах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, зөрчлийг арилгаж ажилласан байна.		

						06 дугаар сарын 25-нд ЭММЗ-н сүүлийн хурал хуралдсанаар хагас жилийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр авагчдын мэдээллийг тулгаж 2025 оны 07 сарын 10-ны дотор ЭММЗ тоон болон бичмэл тайланг гарган ЭММТЗ-д хүргүүлнэ. ЭММЗ-н хурлын үеэр иргэний иргэний үнэмлэхний лавлагаа, ажилласан жилийн лавлагаа зэргийг үндэслэн цахим мэдээллийн сангийн хяналтыг хийдэг. Иргэний бичиг баримтанд үндэслэн хуралдаж буй тул шинжилгээний бичгүүдэд иргэний овог, нэр, нас зэрэг хувийн мэдээллийг хянаж тулгадаг. Сар бүрийн нас барсан иргэдийн жагсаалтын Эрүүл мэндийн төвөөс авч мэдээллийн сангийн хөдөлгөөнийг хийдэг. 2025 оны 06 дугаар сарын 25-нд ЭММЗ-н сүүлийн хурал хуралдсанаар хагас жилийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр авагчдын мэдээллийг тулгаж 2025 оны 07 сарын 10-ны дотор ЭММЗ тоон болон	
--	--	--	--	--	--	---	--

						бичмэл тайланг гарган ЭММТЗ-д хүргүүлнэ.	
4.3.2.	Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх		Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	-	Аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	НДЕГ-н даргын 2025 оны эхний хагас жилийн 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/1244 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, түүнд зонхилох өвчин, шалтгаан зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн ИТХ-н төлөөлөгч, дүүргийн Засаг дарга холбогдох удирдлагууд, ӨЭМТ-н дарга нарт нээлттэй мэдээллийг 37 албан хаагчдыг хамруулан хийв.	85
			Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан		Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна.	Дүүргийн хүн амын ХЧА-н үндэслэлд хяналт хийх, ХЧА-г бууруулах арга замыг судлах, цаашид арга хэмжээний санал боловсруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/152 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэний заалтын үндэслэл, эмчийн явцын хяналт, эмнэлгийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт, эмх цэгцэд хяналт, үнэлгээ хийж	

						хороодоор ажиллаж байна. 2025 оны 06 сарын 09-ний өдөр 2-р хороонд ажлын хэсэгт орсон ЭММЗ-н төрөлжсөн мэргэшлийн эмч нартай ажиллалаа. 2-р хороон нь 684 хүн амтай бөгөөд 29 иргэн буюу 4.2% нь ХЧА-тай иргэн эзэлж байгаа нь улсын дундажаас дээгүүр үзүүлэлт тул хяналт хийж ажиллахад 18 иргэн буюу 62% нь хяналтад биеэр бичиг баримттайгаа ирж хамрагдсан байна. Төлөвлөгөөний дагуу 06 сардаа багтаан бусад хороодод хяналт хийгдэж, дүүргийн удирдлагуудад тайлан тавьж цаашид үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллах юм. ЭММЗ-н хурлын үеэр дотоодын хяналт хийхдээ эмч, мэргэжилтэнд зөвлөгөөг өгч ажилладаг. Тус дүүргийн Эрүүл мэндийн төв нь medsoft программыг ашиглан цахимд шилжсэн тул иргэний үзлэг цахимаас хэвлэгдэн амбулаторийн картанд хавсаргагддаг бөгөөд иргэний үзлэг, шинжилгээ цахимд хадгалагдан, эмч цэгцтэй болсон.	
4.3.3.	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг		Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан	2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан	Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг	ЭММ-н хууль тогтоомжийн талаар 3 удаагийн сургалтад 71 эмч, мэргэжилтэн, Эмнэлгийн хуудасны талаар 2 удаагийн сургалтад 56 эмч,	95

	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах				сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	мэргэжилтэн, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа ЭММЗ-н 10 гишүүн, 2 дугаар хорооны дахин магадлалд хамрагдсан 18 иргэн, ЭММЗ-н хуралд биеэр ирж оролцсон 32 иргэнд нийт 187 эмч, мэргэжилтэн, холбогдох албан хаагч, иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. ЭММЗ-н хурлын явцыг дүрс бичлэгт буулгадаг, хурал эхлэхээс өмнө хурлаар орогсдын нэрсийг дуудаж ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд АТГ-н мэдэгдэх маягт бөглөн мэдэгддэг, хагас жилийн байдлаар 1 тохиолдол гарч маягт бөглөн, зөвлөлийн даргад мэдээлэн ажилласан. Дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдлаар дүүргийн ИТХурлын төлөөлөгч болон ӨЗМТ-н дарга, дүүргийн Засаг дарга холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч 37 албан хаагч хамрагдсан. Нийгмийн даатгалын газрын цахим хаягаар 2 удаагийн постер мэдээлэл байршуулсан, телевиз болон цахим мэдээллийн хуудсанд 2 удаагийн ярилцлага өгч мэдээлэл хийж ажилласан.	
--	--	--	--	--	--	---	--

			Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан	2024 онд 3-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн	Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн магадлалын талаар ерөнхий мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж мэдээллээр хангасан байна.	Дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдлаар дүүргийн ИТХурлын төлөөлөгч болон ӨЗМТ-н дарга, дүүргийн Засаг дарга холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч 37 албан хаагч хамрагдсан. Нийгмийн даатгалын газрын цахим хаягаар 2 удаагийн постер мэдээлэл байршуулсан, телевиз болон цахим мэдээллийн хуудсанд 2 удаагийн ярилцлага өгч мэдээлэл хийж ажилласан.	80
4.3.4.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах		Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо	2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажилласан.	Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	Хагас жилийн байдлаар 18 албан бичиг ирж, 2 судалгааг гарган, 1 албан даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
Зорилт 4.4: “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангах чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.4.3.	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах;		Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах	Нийгмийн даатгалын программ хангамж шинэчлэгдсэнтэй холбоотой байцаагч, албан хаагчдын хандах эрхийн тохиргоог https://sicos.ndaatgal.mn/ дээр олгон ажиллаж байна.	Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангахад анхаарч өөрийн эрхийг бусдад шилжүүлэхгүй байх, түр хугацаагаар ажлын байрыг орхихдоо дэлгэцийг цоожлох, компьютерийн нууц үгийг улирал тутам солих зэрэг журмын дагуу ажиллаж байна.	100
			МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу,	Журмын хүрээнд компьютерийн аюулгүй	МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан		

			судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх	ажиллагааг ханган албан хаагчдад и-мэйл хаяг ашиглах талаар мэдээлэл зөвлөмж хүргэж, ажлаас чөлөөлөгдсөн 3 албан хаагчийн хандах эрхүүдийг цуцлах, ажилд томилогдсон 3 албан хаагчид холбогдох эрх нээлгэх хүсэлтийг НДЕГ-ын дэргэдэх МТТ-д хүргүүлж, шийдвэрлүүлсэн.	бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	Шинэ сикос системийн хөгжүүлэлтээс шалгаалсан алдааг тухай бүр МТТ-д хүргүүлэн шалгуулж ажилаж байна.	
--	--	--	--	---	--	---	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5		7
1	Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох.	Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна.	Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинд байна.	Үндэсний бичигт хөрвүүлэх	Үндэсний бичгийг унших, криллд хөрвүүлэх мэдлэгтэй, дунд шатны сургалтад хамрагдахаар хүлээгдэж байна.	2025.01.01 2025.05.31	50
3	Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах.	Газрын удирдах ажилтнууд манлайллын ур чадварын сургалтад 100 хувь оролцсон байна.		Тухай бүр	Сургалтын төвүүдийн пейжээс сургалт, богино хэмжээний лекц зэргийг судлаж өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлж ажиллаж байна.	2025.03.01 2025.12.31	20
5	Стресс менежментийн хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах.	Стресс менежментийн хөтөлбөрийг боловсруулж амжилттай хэрэгжүүлсэн байна.	-	Тухай бүр	Газрын хүний нөөц, хуулийн мэргэжилтэн А.Ундармаагийн		100

					бэлтгэсэн “Стресс менежмент” сургалт болон цахим мэдээлийн сайтаас энэ талын мэдээллийг судлаж ажил, амьдралдаа хэрэгжүүлэн ажил, амралтын цагаа зөв зохицуулахад анхаарч, улмаар эрүүл мэнддээ анхааран иог дасгалаар хичээллэж байна.	2025.03.01 2025.12.31	
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад хамрагдах.	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 2-оос доошгүй удаа хамрагдсан байна.	-	Тухай бүр	Ёс зүйн хороо, Багануур дүүргийн Засаг даргы тамгын газраас хамтран зохион байгуулсан соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүүгийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж” сэдэвт лекцэнд хамрагдсан. НДЕГ-ын ЁЗДХороо-ноос цахимаар зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” сургалтад хамрагдсан.	2025.03.01 2025.12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.ХЭРЛЭН

2025 оны 06 дугаар сарын 10

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ДАМБИЙН ХЭРЛЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар

Нэгжийн нэр: Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь)	(Биелэлтийн хувь * 70 / 100%)
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт			
1.	Арга хэмжээ 1.1.	95.0	66.5
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт			
1.	Арга хэмжээ 2.2.	95.0	66.5
2.	Арга хэмжээ 2.4.	96.7	67.69
3.	Арга хэмжээ 2.8.	95.0	66.5
4.	Арга хэмжээ 2.10.	85.0	59.5
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт			
1.	Арга хэмжээ 3.1.	100	70.0
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт			
1.	Арга хэмжээ 4.1.	95.0	66.5
2.	Арга хэмжээ 4.6.	100	70.0
3.	Арга хэмжээ 4.8.	95.0	66.5
4.	Арга хэмжээ 4.1.1	100	70.0
5.	Арга хэмжээ 4.1.2	100	70.0
6.	Арга хэмжээ 4.2.1	70.8	49.58
7.	Арга хэмжээ 4.2.2	95.0	66.5
8.	Арга хэмжээ 4.3.1	90.0	63.0
9.	Арга хэмжээ 4.3.2	85.0	59.5
10.	Арга хэмжээ 4.3.3	95.0	66.5
11.	Арга хэмжээ 4.3.4	80.0	56.0
12.	Арга хэмжээ 4.4.3	100	70.0
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт			
1.			
2.			
Дундаж оноо:			65.0

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.	50	7.5
2.	Арга хэмжээ 3.	20	3.0
3.	Арга хэмжээ 5.	100	15.0
4.	Арга хэмжээ 6.	100	15.0

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо	10.12
---	-------

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1. Компьютерийн хэрэглээ, техник хэрэгслийн ашиглалт	15
8.	Мэргэжлийн ур чадвар 2. Хууль эрх зүйн мэдлэг, ур чадвар	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3. Архив албан хэрэг хөтлөлтийн ур чадвар	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15.0

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 65.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 10.12
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 15.0
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	 оноо
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		90.1

Үнэлгээ өгсөн:

Газрын дарга

Р.Өнөржаргал

2015 оны 06 дугаар сарын 23

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Тэтгэвэр, тэтгэмжийн
хэлтсийн дарга

Д.Хэрлэн

2015 оны 06 дугаар сарын 23